



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 04 сарын 03 өдөр

Дугаар А/138

Хэрлэн сум

2017 оны 1 дүгээр ээлжийн цэрэг татлагыг
зохион байгуулж явуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Цэргийн албаны тухай тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.4, 13 дугаар зүйлийн 13.1, Засгийн газрын 2017 оны мн/52 дугаар тогтоол, Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын н/33 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2017 оны 1 дүгээр ээлжийн цэрэг татлагыг 4 дүгээр сарын 21-нээс 5 дугаар сарын 15-ны хооронд зохион байгуулж явуулсугай.

2. 2017 оны 1 дүгээр ээлжийн цэрэг татлагын товчоог дор дурдсан бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Товчооны дарга:	Ж.Ганбаатар	-Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга
Орлогч дарга:	Н.Хүрэлээ	-Цэргийн штабын дарга, дэд хурандаа
Гишүүд:	Д.Батжаргал	-Онцгой байдлын газрын дарга, онцгой байдлын хурандаа
	О.Ганбат	-Цагдаагийн газрын дарга, цагдаагийн хурандаа
	Д.Төгсөө	-Тагнуулын хэлтсийн дарга, хурандаа
	Ц.Гэрэлмаа	-Эрүүл мэндийн газрын дарга
	С.Мөнхцэцэг	-Боловсрол, соёл, урлагийн газрын дарга
	Ц.Идэрбат	-Хэрлэн сумын Засаг дарга бөгөөд Чингис хотын Захирагч
Нарийн бичгийн дарга:	Л.Цэнддорж	-Цэргийн штабын Тоо бүртгэлийн офицер, ахмад

3. Цэрэг татлагын хуваарийг 1 дүгээр, үйл ажиллагааны зардлыг 2 дугаар хавсралтаар баталсугай.

01 678

4. 2017 оны 1 дүгээр ээлжийн цэрэг татлагаар Зэвсэгт хүчний Жанжин штабаас тогтоосон хяналтын тоог баримтлан, хуульд заасан шаардлага хангасан залуучуудыг хугацаат цэргийн албанд татаж, үдэх ажлыг өндөр хэмжээнд зохион байгуулан 5 дугаар сарын 10-ны дотор багтаан алба хаах цэргийн ангидад хүлээлгэн өгч, 5 дугаар сарын 15-нд илтгэхийг Цэрэг татлагын товчоо /Ж.Ганбаатар/-нд үүрэг болгосугай.

5. Зэвсэгт хүчний Жанжин штабаас тогтоосон хяналтын тоог баримтлан 19-29 насны хугацаат цэргийн алба хаасан, гэрээт цэргийн албанд элсэх хүсэлтэй залуучуудыг журмын дагуу сонгон шалгаруулж, бичиг баримтыг бүрдүүлэн Зэвсэгт хүчний Төв дамжин өнгөрүүлэх баазад хүргүүлэхийг Цэрэг татлагын товчоо /Ж.Ганбаатар/-нд даалгасугай.

6. Цэрэг татлагын үед мэргэжлийн эмч нарын үзлэгийг зааврын дагуу чанартай явуулах, эмчлэгдэн эдгэрэх боломжтой залуучуудыг эрүүлжүүлэх ажлыг зохион байгуулахыг Эрүүл мэндийн газар /Ц.Гэрэлмаа/-т, цэргийн албанд татагдагсадын боловсролын түвшинг харгалзан үзэх, бичиг үсэг үл мэдэгч, бага боловсролтой иргэдийг албан бус сургалтанд хамруулан боловсролыг дээшлүүлэх, цэргийн албан татагдагсадын үдэн гаргах арга хэмжээг зохион байгуулахыг Боловсрол, соёл, урлагийн газар /С.Мөнхцэцэг/-т үүрэг болгосугай.

7. Цэргийн албанд татагдагсадын гэмт хэрэг зөрчилд холбогдож байсан эсэхийг хянах, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж, хэв журмын зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авахыг Цагдаагийн газар /О.Ганбат/-т, цэрэг татлагын байрны дотоод дэг журам сахиулах, цэрэг татлагын товчооны ажилд дэмжлэг үзүүлэхийг Онцгой байдлын газар /Д.Батжаргал/-т, цэрэг татлагыг зохион байгуулах байр, ажиллах нөхцөл, хоол хүнсээр хангахыг сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

8. 2017 орны 1 дүгээр ээлжийн цэрэг татлагын ажлыг зохион байгуулах бие бүрэлдэхүүнийг хоол хүнсээр хангах, цэргийн албанд татагдагсадыг аймгийн цэрэг татлагын байранд ирүүлэх, цэргийн албанаас халагдагсадыг бичиг баримттай нь хүлээн авч, сумдын Засаг даргын Тамгын газрын дарга нарт хүлээлгэн өгч, орон нутагт хүргэх ажлыг зохион байгуулахыг Цэргийн штаб /Н.Хүрэлээ/-т даалгасугай.

9. 2017 оны 1 дүгээр ээлжийн цэрэг татлаганд шаардагдах 4499480 /дөрвөн сая дөрвөн зуун ерэн есөн мянга дөрвөн зуун наян/ төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн Цэрэг татлагын зардлаас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /С.Нямдаваа/-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

Аймгийн Засаг даргын 2017 оны 04.
дүгээр сарын 05 өдрийн 4/138 дугаар
захирамжийн нэгдүгээр хавсралт

2017 ОНЫ 1 ДҮГЭЭР ЭЭЛЖИЙН ЦЭРЭГ ТАТЛАГЫН
ЗОХИОН БАЙГУУЛАХ ХУВААРЬ

№	Сум, багийн нэр	Үзлэгээр орох хүний тоо	Тэнцүүлэн татах хүний тоо	Цэрэг татлагад орох газар	Үзлэгт бэлэн байх	
					Сар өдөр	Цаг
1.	Бэрх	121	9	Бэрх	04.21	09.00
2.	Батноров	152	11	Батноров		11.00
3.	Баян-Овоо	52	3	Баян-Овоо	04.22	09.00
4.	Норовлин	88	7	Норовлин		16.00
5.	Дадал	133	10	Дадал	04.23	09.00
6.	Баян-Адарга	71	6	Баян-Адарга	04.24	09.00
7.	Биндэр	123	9	Биндэр		13.00
8.	Батширээт	71	6	Батширээт	04.25	09.00
9.	Гурванбаян	52	3	Гурванбаян	04.25	13.00
10.	Өмнөдэлгэр	257	19	Өмнөдэлгэр	04.26	09.00
11.	Өлзийт	58	5	Өлзийт	04.26	16.00
12.	Хэрлэн	895	65	Хэрлэн	04.29-30	09.00
13.	Баянхутаг	6	1	Хэрлэн	04.30	09.00
14.	Галшар	6	1			
15.	Бор-Өндөр	29	3			
16.	Дархан	6	1			
17.	Баянмөнх	3	1			
18.	Дэлгэрхаан	4	1			14.00
19.	Хэрлэнбаян-Улаан	4	1			
20.	Цэнхэрмандал	6	1			
21.	Жаргалтхаан	5	1			
22.	Мөрөн	3	1			
	Нийт дүн	2073	150			

2017 ОНЫ 1 ДҮГЭЭР ЭЭЛЖИЙН ЦЭРЭГ ТАТЛАГЫН ЗОХИОН БАЙГУУЛАХ ТӨСӨВ

Нэг. Шатахууны зардал

№	Сумын нэр	Машины марк	Тоо	Явах км	Зарцуулах шатахуун	Нийт үнэ	Тайлбар
1	Цэрэг татлагын товчоо	Пургон	1	757	136	209440	Сумдаар урьдчилсан үзлэг хийх
		Бенз-250	1	850	142	234300	УБ цэргийн хүрээний ангиудад цэрэг хүргэх, тооцоо хийх
2	Мөрөн	Пургон	1	60	10	15400	Чингис хотод цэрэг хүргэх, буцах
3	Өлзийт	Пургон	1	100	18	27720	—//—
4	Өмнөдэлгэр	Пургон	1	200	36	55440	—//—
5	Гурванбаян	Пургон	1	260	47	72380	—//—
6	Батширээт	Пургон	1	380	68	104720	—//—
7	Биндэр	Пургон	1	360	65	100100	—//—
8	Баян-Адарга	Пургон	1	320	57	87780	—//—
9	Дадал	Пургон	1	540	98	150920	—//—
10	Норовлин	Пургон	1	400	72	110880	—//—
11	Батноров	Пургон	1	200	36	55440	—//—
12	Баян-Овоо	Пургон	1	270	48	73920	—//—
13	Бэрх	Пургон	1	140	25	38500	—//—
14	Хэрлэн	Пургон	1	100	18	27720	—//—
15	Баянхутаг	Пургон	1	50	9	13860	—//—
16	Галшар	Пургон	1	290	52	80080	—//—
17	Бор-Өндөр	Зил-130	2	740	280	431200	—//—
18	Дархан	Пургон	1	290	52	80080	—//—
19	Баянмөнх	Пургон	1	200	36	55440	—//—
20	Дэлгэрхаан	Пургон	1	290	52	80080	—//—
21	ХБулаан	Пургон	1	360	64	98560	—//—
22	Цэнхэрмандал	Пургон	1	290	52	80080	—//—
23	Жаргалтхаан	Пургон	1	200	36	55440	—//—
						2339480	

Хоёр. Цэрэг татлагын товчооны хоолны зардал

№	Сар өдөр	1 удаа хоолох хүний тоо	Хоног	Нийт хүний тоо	Салат		Хоол		Нийт үнэ
					Нэг бүрийн үнэ	Бүгд үнэ	Нэг бүрийн үнэ	Бүгд үнэ	
1	4/29-4/30	35	2	70	3000	210000	5500	385000	595000
2	5/01-5/02	15	2	30	3000	120000	5500	165000	285000
3	4/29-5/02	15	4	60			5500	33000	330000
									1210000

Гурав. Томилолтын зардал

№	Газрын нэр	Хүний тоо	1 хоногийн томилолт	Хоног	Мөнгөн дүн
1	Сумдаар	10	12000	5	600000
2	УБ хотод	3	18000	5	270000
	Дүн				870000